



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/360

Улаанбаатар хот

Сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулах
журам батлах тухай ✓

"МУБИС-ийн дүрэм"-ийн 4.4.1, "МУБИС-ийн сургалтын журам"-ын 1.3, МУБИС-ийн захирлын зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн мөрдөгдөх бакалаврын сургалтын төлөвлөгөөнд сайн дурын үйл ажиллагааны 2 кредитийн хичээл тусгагдсантай холбогдуулан сайн дурын ажил зохион байгуулах журмыг хавсралтаар баталсугай.


2. Сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулах журмыг сургалтын үйл ажиллагаанд мөрдөн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Оюутны хөгжлийн албаны дарга /Г.Батсуурь/-д, бүрэлдэхүүний сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгч, хөтөлбөрийн албадын дарга нарт даалгасугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт эрхэлсэн дэд захирал /Х.Тамир/-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Д.МАНДАХ

МУБИС-ийн захирлын
2019 оны дугаар сарын 10-ны
өдрийн дугаар тушаалын
хавсралт



САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь МУБИС-д бакалаврын хөтөлбөрөөр суралцагч оюутны сайн дурын үйл ажиллагаа санаачлан хийх, сайн дурын үйл ажиллагаанд оролцох болон оюутны сайн дурын ажлыг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Монгол Улсын Үндсэн Хууль (1992)-д эх орондоо хүмүүнлэг иргэний нийгэм байгуулахыг эрхэм зорилго болгосон байдаг бөгөөд иргэн бүр нийтийн сайн сайхны төлөө өөрийн хувь нэмрийг оруулахыг эрмэлздэг, түүнээ хэрэгжүүлдэг байх нь дээрх зорилгыг хэрэгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр болох юм.
- 1.3. Уг журам нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024), МУБИС-ийн Хөгжлийн бодлого (2014-2024), “Шинэ зууны багшийн загвар”, МУБИС-ийн Оюутны хөгжлийн хөтөлбөр (2019-2024) зэрэг эрх зүйн баримт бичгүүд болон холбогдох бусад хууль тогтоомжид үндэслэнэ.
- 1.4. Сайн дурын ажил нь их дээд сургуулийн оюутан, төгсөгчдийг үнэлэх нэг гол үзүүлэлт болох бөгөөд суралцах хугацаандаа тэдний нийгэм хүмүүнлэгийн болон сайн дурын үйл ажиллагаанд хэрхэн оролцож байсныг харгалзах үндэслэл болно. Энэ нь оюутан, төгсөгчдийг цаашид суралцахад улмаар хөдөлмөрийн зах зээл дээр гараад ажиллахад энэхүү үзүүлэлт нь мэргэжилтэнд тавигдах бас нэг шалгуур болно.
- 1.5. “Сайн дурын ажил” гэж хувь хүн, байгууллага хамт олон, нийгмийн бүлгүүд, засаг захиргааны нэгжүүд, бүс нутаг, улс орон, тив, дэлхийд тулгамдсан хүндрэл бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд өөрсдийн санал санаачлагаар оролцох, тусламж, дэмжлэг үзүүлэхийг хэлнэ.
- 1.6 “Сайн дурын оюутан” гэж журмын 1.5-т дурдсан ажилд МУБИС - ийн нэрийн өмнөөс сайн дураараа оролцдог, МУБИС-ийн сайн дурын төв /Оюутны хөгжлийн алба/-д бүртгэлтэй суралцагчийг хэлнэ.

Хоёр. Сайн дурын үйл ажиллагаанд баримтлах зарчим

- 2.1. Сайн дурын үйл ажиллагаа нь: сайн дурын, хууль ёсны, тэгш эрхийн зарчимд тулгуурлах бөгөөд үнэ төлбөргүй, улс төрийн, шашны, арилжааны зорилгогүй байна.
- 2.2. Сайн дурын үйл ажиллагааны тухай мэдээлэл ил тод, ойлгомжтой, хүртээмжтэй байна.
- 2.3. Сайн дурын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хангаж ажиллах бөгөөд ямар нэгэн ялгаварлан гадуурхалгүй байна.
- 2.4. Сайн дурын үйл ажиллагаа нь оюутнуудын эв нэгдэл, хамтын ажиллагаа, чин сэтгэлд үндэслэсэн байна.

Гурав. Сайн дурын үйл ажиллагааны зохион байгуулалт

- 3.1 Оюутны сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулах үндсэн нэгж нь бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн алба, мэргэжлийн тэнхим байх бөгөөд МУБИС-ийн Оюутны хөгжлийн алба нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.
- 3.2 МУБИС-ийн Оюутны хөгжлийн алба нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангахдаа сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулдаг хувь хүн байгууллагуудыг судлах, тэдгээртэй холбоо тогтоох, хамтран ажиллах зэрэг ажлыг зохион байгуулна.
- 3.3 Бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн алба сургуулийн түвшинд сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулахад мэргэжлийн тэнхим болон оюутанд үйлчлэх ажилтнуудыг удирдлага зохион байгуулалтаар хангана.
- 3.4 Бүрэлдэхүүний сургуулийн оюутанд үйлчлэх ажилтан сайн дурын ажлын талаар мэдээлэх, зөвлөн туслах, өөрийн хариуцсан оюутнуудын сайн дурын ажлын цагийг баталгаажуулан сургалтын удирдлага мэдээллийн системд оруулах ажлыг зохион байгуулна.
- 3.5 Мэргэжлийн тэнхим өөрсдийн оюутны сайн дурын үйл ажиллагааны талаарх мэдээлэл өгөх шаардлагатай тохиолдолд сургалт явуулах, сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллана.
- 3.6 Энэхүү журмын 6.1-д заасан сургалтыг МУБИС-ийн Оюутны хөгжлийн алба, Сургалтын хөтөлбөр, багшийн хөгжлийн алба, бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн албад, сургагч багш нартай хамтран зохион байгуулна.
- 3.6 Оюутан бүр сайн дурын ажлын дэвтэр /эсвэл бүртгэлийн хуудас/-тэй байх бөгөөд суралцах хугацаандаа 45-64 хүртэл цагийн ажлыг хийж дэвтэр /бүртгэлийн хуудас/-т тэмдэглүүлнэ. Бакалаврын зэргийн дипломын хавсралт, тодорхойлолтод оюутны хийсэн сайн дурын ажлын нэр, цагийг тэмдэглэнэ.
- 3.7 Сайн дурын ажилд оролцоогүй оюутны дипломын хавсралт, тодорхойлолтод тухайн оюутныг сайн дурын ажил хийгээгүйг заавал дурдана.

Дөрөв. Сайн дурын үйл ажиллагааны хүрээ

- 4.1 МУБИС-ийн оюутны сайн дурын үйл ажиллагааг дараах салбаруудын хүрээнд хэрэгжүүлнэ.
- 4.1.1 Эрүүл мэнд:
- өвчтөний асаргаа сувилгаа хийх
 - эмнэлэг дээр ажиллах
 - бүлэг зохион байгуулах
 - мэдээлэл, сурталчилгаа хийх
- 4.1.2 Боловсрол:
- Сургууль, цэцэрлэг (зорилтот бүлгийн хүүхдүүд хамрагддаг) –т сайн дурын үйлчилгээ үзүүлэх
 - Өдөр өнжүүлэх бүлэгт ажиллах, туслах
 - Хүүхдийн чөлөөт цагийг зөв, оновчтой хэлбэрээр өнгөрөөх
 - Хүүхдийн бүлэг дэмжих
 - Хүүхдийг амьдрах ухаанд сургах, халамжлах
- 4.1.3 Нийгмийн халамж, хамгаалал:
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, гэр бүлтэй ажиллах дэмжлэг үзүүлэх
 - Нийгмийн халамж хамгааллын чиглэлээр зохион байгуулагдаж байгаа бусад үйл ажиллагаанд оролцох
- 4.1.4 Хүрээлэн байгаа орчин

- Байгаль орчныг хамгаалах
- Хог хаягдал цэвэрлэх
- Мод, зүлэг тарих
- Орчны тохижилт хийхэд оролцох



4.1.5 Олон нийтийн арга хэмжээ:

- Бүс нутгийн, улсын, олон улсын чанартай эрдэм шинжилгээний хурлын зохион байгуулалтад оролцох
- Бүс нутгийн, улсын, олон улсын чанартай спорт, урлаг, соёлын арга хэмжээний зохион байгуулалтад оролцох

4.1.6 МУБИС-ийн хүрээнд:

- Сургуулийн зүгээс зохион байгуулж буй аливаа арга хэмжээнд оролцох
- Сургуулийн орчинд сайн дурын үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлэх
- Сайн дурын болон хамтын үйл ажиллагаанд оролцох
- Соёлын болон хүнлэг энэрэнгүй үйлст оролцох

4.2 Хүн амын бүлгийн хувьд дараах хүрээг хамарна. ✓

- Хүн амын зорилтот бүлэг буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэн ба хүүхэд
- Бага орлоготой, ажилгүй иргэн
- Бүтэн өнчин хүүхэд, эцэг эхийн хараа хяналтгүй хүүхэд
- Ахмад настан

Тав. Сайн дурын ажил зохион байгуулагч

- 5.1 МУБИС-ийн сайн дурын үйл ажиллагааны үндсэн зохион байгуулагч нь оюутанд үйлчлэх ажилтан байна.
- 5.2 Холбогдох байгууллага, албан тушаалтан энэхүү журмын 4 дэх хэсэгт заасан хүрээний сайн дурын үйл ажиллагаа явуулах санаачилга, мэдээлэл ирүүлсэн тохиолдолд сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулна.
- 5.3 МУБИС-ийн оюутан энэхүү журмын 4 дэх хэсэгт заасан хүрээний сайн дурын ажлыг санаачлан зохион байгуулах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд мэргэжлийн тэнхим, хөтөлбөрийн алба, оюутан үйлчлэх ажилтны дэмжлэгтэйгээр зохион байгуулна.
- 5.4 Сайн дурын ажил зохион байгуулагч нь оюутныг нийгэм-хүмүүнлэгийн үйл ажиллагаанд оролцуулах, сайн дурын үйл ажиллагааг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх үйл хэрэгт хамруулах, бие даасан, оролцоот, санаачлагатай иргэн болох чадвар хандлагыг төлөвшүүлэх зорилгын хүрээнд сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулна.

Зургаа. Сайн дурын ажилд оролцогч оюутан

- 6.1 Сайн дурын ажилд оролцогч оюутан нь сайн дурын ажил хийхийн өмнө 6-аас доошгүй цагийн сургалтад суух бөгөөд сорил шалгалт өгч, сайн дурын үйл ажиллагаанд оролцох эрхийн сертификат авсан байна.
- 6.2 Сайн дурын ажилд оролцогч оюутан нь сайн дурын ажил хийхдээ энэхүү журмын Хавсралт 2-т байгаа маягтыг ашиглах бол улирал бүрийн төгсгөлд өөрийн хариуцсан оюутанд үйлчлэх ажилтанд хандан Хавсралт 1-ийг бөглүүлнэ.
- 6.3 Сайн дурын ажилд оролцогч оюутан дараах үндсэн чиг үүрэгтэй. Үүнд:
 - 6.3.1. Хүнлэг энэрэнгүй, ээлтэй нийгмийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
 - 6.3.2. Хувь хүний онцлог, ялгаатай байдлыг хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй

байх, тухайн хүмүүсийн нас сэтгэлзүй болон хувийн онцлогийг хүндэтгэн үзэж ажиллах;

- 6.3.3. Сайн дурын ажилд сайн дурын ажилтны өс зүйн хэм хэмжээг мөрдөх;
- 6.3.4. Сайн дурын ажилд өөрийн хүсэл, санаачлагаар оролцох, хариуцлагатай хандах;
- 6.3.5. Сайн дурын ажил хийхдээ ажлаа урьдчилан төлөвлөж шалгах, хийж гүйцэтгэснийхээ дараа заавал тэмдэглэл хөтлөх, багаар хэлэлцэж үр дүнг тодорхойлох;
- 6.3.6. Сайн дурын ажлын төлөвлөгөө, хуваарь, цагаа баримтлах;
- 6.3.7. Сайн дурын ажил зохион байгуулах болон оролцоход тохиолдож болох хүндрэл бэрхшээлийг өөрөө болон багаараа даван туулахад бэлэн байх;
- 6.3.8. Сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулагч, багш, ажилтны удирдлага дор хүлээсэн үүргээ биелүүлэх;
- 6.3.9. Сайн дурын үйл ажиллагаа, хувь хүний болон байгууллагын нууцтай холбоотой мэдээлэл, гэрэл зураг, видео бичлэгийн нууцлалыг хадгалах;
- 6.3.10. Сайн дурын үйл ажиллагаанд оролцох явцдаа олж авсан мэдээлэл, гэрэл зураг, бичлэг зэргийг хувь хүний болон зохион байгуулагчийн зөвшөөрөлгүйгээр үл ашиглах;
- 6.3.11 Сайн дурын үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад зохион байгуулагчаас итгэмжлэн өгсөн техник тоног төхөөрөмж, эд зүйлтэй зүй зохистой харилцах;
- 6.3.12 Сайн дурын үйл ажиллагаанд оролцох явцад дарамт, хүчирхийлэл болон аливаа хууль бус үйлдлийн сэжиг таамаг илэрвэл нэн даруй зохих байгууллага, эрх бүхий этгээдэд мэдээлэх;

Долоо. Сайн дурын ажилд хориглох зүйл

7.1 Сайн дурын ажилд дараах зүйлийг хориглоно. Үүнд:

- 7.1.1 Сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулагчийн /багш, ажилтан/ зөвшөөрөлгүйгээр хүлээсэн үүргээ бусдад шилжүүлэх, бусдын өмнөөс үүрэг гүйцэтгэх;
- 7.1.2 Сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулагчид урьдчилан мэдэгдэлгүйгээр үүргээ биелүүлэхээс татгалзах, үйл ажиллагааг тасалдуулах
- 7.1.3 Сайн дурын үйл ажиллагаа хийх явцдаа улс төрийн болон шашны үйл ажиллагаа явуулах, сурталчлах;
- 7.1.4 Сайн дурын үйл ажиллагаанд оролцох үедээ бүдүүлэг зан авир гаргах, мансуурах, согтууруулах ундаа хэрэглэх;
- 7.1.5 Хувь хүн, байгууллагын нэрийн өмнөөс хандив цуглуулах, хандивыг хувийн дансаар авах, ашиглах;
- 7.1.6 Сайн дурын үйл ажиллагаатай холбогдох үнэмлэх, бичиг баримт, дэвтрийг хууль бусаар ашиглах, хуурамч мэдээлэл оруулах;


Найм. Санхүүжилт, хэрэгжилтийн үнэлгээ

8.1 Сайн дурын ажлын талаарх 6 цагийн сургалт зохион байгуулсан багшийн ажлын хөлсийг илүү нэмэлт кредитийн үнэлгээгээр тооцож, бүрэлдэхүүний сургууль олгоно.

8.2 Сайн дурын үйл ажиллагааны дэвтэр болон МУБИС-ийн сайн дурын ажил хийж буй оюутны таних тэмдэг (хантааз) - ийн зардлыг бүрэлдэхүүний сургуулийн төсөвт тусгана.

8.3 Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн 6-р сард бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн албад гарган, МУБИС-ийн Оюутны хөгжлийн албанд ирүүлнэ.

8.4 Оюутны хөгжлийн алба, Хяналт үнэлгээний албатай хамтран хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд үнэлгээ хийн дүгнэлт гаргана.





Холбоо барих утас: _____ Имэйл хаяг: _____

№	Сайн дурын үйл ажиллагааны чиглэл	Улирал							
		I	II	III	IV	V	VI	VII	VIII
1	Сайн дурын ажлын талаарх лекцэд хамрагдах /8 цаг/								
2	Эрүүл мэндийн чиглэлээр								
3	Боловсролын чиглэлээр								
4	Нийгмийн халамж хамгааллын чиглэлээр								
5	Хүрээлэн буй орчны чиглэлээр								
6	Олон нийтийн арга хэмжээний чиглэлээр								
7	МУБИС-ийн хүрээнд хийсэн ажлууд								
8	Нийт								

Огноо: _____

Бүрэлдэхүүн сургуулийн Хөтөлбөрийн албаны тэмдэг



Сайн дурын оюутны ажилласан цагийн хуудас

Овог нэр: _____

Оюутны код: _____ Сурагцаж байгаа мэргэжил: _____

Холбоо барих утас: _____ Имэйл хаяг: _____

Огноо	Эхэлсэн цаг	Дууссан цаг	Сайн дурын ажил хийсэн газар/салбар	Сайн дурын үйл ажиллагаа
Нийт цаг				

Сайн дурын оюутны гарын үсэг: _____ Огноо: _____

Сайн дурын ажлыг баталгаажуулсан ажилтны гарын үсэг: _____ / _____ /

Огноо: _____

Сайн дурын ажил зохион байгуулсан байгууллагын тамга



Сайн дурын оюутны ажилласан цагийн хуудас

Овог нэр: _____

Оюутны код: _____ Суралцаж байгаа мэргэжил: _____

Холбоо барих утас: _____ Имэйл хаяг: _____

Огноо	Эхэлсэн цаг	Дууссан цаг	Сайн дурын ажил хийсэн газар/ салбар	Сайн дурын үйл ажиллагаа
Нийт цаг				

Сайн дурын оюутны гарын үсэг: _____ Огноо: _____

Сайн дурын ажлыг баталгаажуулсан ажилтны гарын үсэг: _____ / _____ /
Огноо: _____

Сайн дурын ажил зохион байгуулсан байгууллагын тамга